



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/З/16

Хэрлэн сум

Уулзалт зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн удирдлагууд төрийн бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, цаг үеийн ажлын талаар багийн иргэдэд мэдээлэл хүргэх, тэдний санал хүсэлтийг сонсож, төрийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах зорилгоор 18 сум 89 багт хийх уулзалтыг 2024 оны 09 дүгээр сарын 03-аас 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Уулзалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Ж.Гантулга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд	Ч.Баярцолмон	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Дарханбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Н.Зоригтбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	С.Оюун-Эрдэнэ	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.

Б.Энх-Уянга

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн

Ж.Цэнджав

Нийгмийн бодлогын хэлтсийн
Мэргэжилтэн

3.Багт ажиллах бүрэлдэхүүн, хуваарийг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ